

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№22/561

ШУС, НУС

2021

Ж.ЦЭВЭЭН СУДЛАЛД ХОЛБОГДОХ ШИНЭ БАРИМТ ОЛДОВ

Л.Норовсүрэн*, Д.Нарантуяа**

* МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

** МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үгс: Гавьяат үйлс, баруунтан, соёл боловсрол, Ардын нам, дэд дарга, Тунхаглан зарлах бичиг, тахиа жил, Хиагт хот, эрмэлзэх зүйл.

Энэхүү өгүүллийг тэрлэгч миний бие Монголын анхны тогтмол хэвлэлийг үүсгэн байгуулсан гэдэг утгаар нь Ж.Цэвээний амьдрал үйлс, бүтээл туурвилыг чадлын хэрээр сонирхон судалдаг нэгэн билээ. Хориод оны хоёрдугаар хагасаас эхлэн түүнийг барууны үзэлтэн хэмээн хавчиж гадуурхан монгол нутгаас гарахаас өөр аргагүй болгож, улмаар Орос оронд хилс хэргээр шоронд хорьж амь насыг нь егүүтгэсэн билээ. Тэр цагаас эхлэн Ж.Цэвээнийг эсэргүү үзэлтэн, барууны үзлийг сурталчлагч хэмээн харлуулж, байгуулсан гавьяа зүтгэлийг нь хав дарах болсон юм. Тавиад оны сүүлчээр цагаатгасан боловч нэр төрийг нь дорвитой сэргээж, Монголын оюуны салбарт оруулсан гавьяат үйлсийг зохих байранд нь тавих талаар хангалтгүй явж иржээ. Миний хувьд түүнийг ХХ зууны эхэн үеийн Монголын оюун санааны эцэг,

Дорно дахиныг судлагч нэрт эрдэмтэн, соён гэгээрүүлэгч гэж үздэг бөгөөд энэ үзлээ өөрийн бүтээлүүдэд удаа дараа илэрхийлж ирсэн билээ.

Ж.Цэвээн Монголын үндэсний сэтгүүл зүйн эхлэлийг тавьсан “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинуудыг эрхлэн гаргаж мэдээллийн эринийг эхлүүлснээс гадна Монголын анхны хэвлэх үйлдвэрийг санаачлан байгуулж, шинэ цагийн сургууль боловсролыг хөгжүүлэхэд хүч мэдлэгээ зориулж, шинжлэх ухааны байгууллагын эх суурийг тавилцаж, ардын нам, ардын хувьсгалын үйл хэрэгт идэвхтэй оролцож явсан баримтууд болно.

Эдгээрээс Монголын соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт хийж гүйцэтгэсэн гавьяат үйлс нь тодорхой баримтуудаар баталгаажиж, олон нийтэд аль хэдийн ил болсон юм. Харин Монгол Ардын Намыг байгуулахад ямар үүрэгтэй оролцсон тухайд өнөөг хүртэл тодорхой ярьж, бичсэн зүйл ховор байв. Гэтэл тэр бээр Монгол Ардын Намын ууган зүтгэлтэн, голлох үзэл

сурталч нь байсныг гэрчлэх цагаан цаасан дээр хараар бичсэн баримт Монголын үндэсний архив, Намын түүхийн архивын даргаар олон жил ажилласан түүх судлаач, архивч Ч.Мижээхүү агсны хувийн архиваас олдлоо. Тэрхүү баримт бичиг нь Монгол Ардын Намын 1921 оны 3 дугаар сарын 1-нд хуралдсан Их хурал (тухайн үед “ардын намын хурал” гэж нэрлэсэн бөгөөд 1924 оноос Их хурал гэх болсон), 3 дугаар сарын 2, 3-ны өдрүүдэд болсон зөвлөгөөний тэмдэглэл, Ардын намаас түмэнд тунхаглан зарлах бичгийн оршил, Намын эрмэлзэх арван зүйл, Их хурал, зөвлөгөөнд оролцсон хүмүүсийн нэрс зэргээс бүрдсэн цогцолбор шинжтэй эх сурвалж юм.

Нэг: Ж.Цэвээн Монгол Ардын Намыг үүсгэн байгуулагчдын нэг байжээ. Юуны өмнө тэр бээр 1921 оны 3 дугаар сарын 1-нд Хиагтад хуралдсан Намын анхдугаар Их хурлын дэд даргаар сонгогдож байжээ. Энэ тухай “Монголын ардын намын хурлын бичиг” гэсэн бичмэл баримтад “Цагаагчин тахиа жилийн цагаан сарын 24-ний өдөр. Хиагт хотноо өдрийн 12 цагт Монгол Ардын Намын 26 хүмүүс ба гишүүд нь хамтран хурлын даргад Сүхбаатар, дэд даргад Цэвээн, бичээч нарт Одсэр, Дамбадорж, Балмасоо нарыг сонгов” (Монгол Ардын Намын хурлын бичиг, 1921) хэмээн тэмдэглэсэн байна.

Хоёр: Тус Их хурлаар “Нэгдүгээр, Дэлхий дэх олон улсын намуудын хооронд найрамдлыг зузаатгах баярын цахилгаан мэдээ-

ний тухай, Хоёрдугаар, Ардын намын эрмэлзэх зүйлүүдийг баталж авах тухай, Гуравдугаар, Ардын намын төв хороо байгуулах тухай” гэсэн гурван асуудал хэлэлцжээ. Хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөө ёсоор Коминтерны Алс Дорнодын хэлтсээс ирүүлсэн баярын цахилгааныг танилцуулж, хариу цахилгаан явуулахаар тохирч, Намын эрмэлзэх арван зүйл буюу дүрмийг баталж, Намын удирдах бүрэлдэхүүнийг сонгосон байна. Энэ тухай хурлын тэмдэглэлд “Нэгдүгээр зүйлийн тухай хэлэлцээд мөн цахилгаан мэдээг явуулахыг бүгдээр сайшаан хүлээв. Хоёрдугаар зүйлийн тухай Дэлхий дэх Олон улсын намуудын хамтарсан Төв хорооны Алс Дорнодын хэлтсээс явуулсан бичиг хэмээх энэхүү Төв Хорооны байгуулсан учрыг дэлгэрэнгүйгээр мэдүүлж, Монгол Ардын Намын аливаа үйлсийг маш бадруулан олон ардуудын эрдэм соёлд боловсорч жаргах болтугай хэмээн ерөөл тавив” (Монгол Ардын Намын хурлын бичиг, 1921) гэжээ.

Гурав: Намын анхдугаар Их хурлаас баталсан “Монгол Ардын намаас түмэнд тунхаглан зарлах бичгийн оршил”, “Намын эрмэлзэх арван зүйл” гэсэн үндсэн хоёр баримт бичгийг Ж.Цэвээн боловсруулж хуралд оруулан хэлэлцүүлсэн байна. Энэ тухай мөнөөх “Монголын ардын намын хурлын бичиг” гэсэн тэмдэглэлд “Ардын намын гишүүн Цэвээн хэмээхээр “Ардын намын оршил бичиг”, Эрмэлзэх зүйлүүдийг зохиож хуралд өргөсөн нь хуралд олон гишүүн нар

нэгэн дуугаар сайшаан энэхүү оршил бичгийг хүлээв. Үүнээс гадна мөн өдөрт Ардын намыг тунхаглан зарлах тухай хэлэлцээд Монгол Ардын Намын дүрмийг товчлон арван зүйлээр бичиж батлав. Оршил ба эрмэлзэх зүйлүүдийг тусгай жагсаан бичив” (Монгол Ардын Намын хурлын бичиг, 1921) гэсэн байна.

Дөрөв: Ж.Цэвээн бүр 1921 оны эх, магадгүй түүнээс ч өмнө Монгол Ардын Намын гишүүн болсон байжээ. Үүнийг хурлын тэмдэглэлд «“Ардын намын гишүүн Цэвээн хэмээхээр “Ардын намын оршил бичиг”, Эрмэлзэх зүйлүүдийг зохиолгож хуралд өргөсөн”» (Монгол Ардын Намын хурлын бичиг, 1921) гэснээс тодорхой мэдэж болно. Тэр тусмаа шинэ тутам байгуулагдаж байсан намын үндсэн баримт бичгүүдийг зохиохыг түүнд даалгасан нь нам дотор түүний эзэлж байсан байр суурь, эрдэм мэдлэгийн зиндааг харуулж байна. Хурлын тэмдэглэлд дурдсанаас үзэхэд Цэвээнний боловсруулсан “Намын эрмэлзэх арван зүйл”-ийг нам болон түүний гишүүдийн дагаж мөрдөх дүрэм болгон баталж, харин “Түмэнд тунхаглан зарлах бичгийн оршил”-ыг нэгэн дуугаар сайшаасан ажээ. Оршил бичиг нь намын үйл ажиллагаанд үйлчлэх албан ёсны акт биш, тухайн үеийн дэлхий дахины олон улсын байдал хийгээд монгол орны улс төр, нийгмийн амьдралд өгсөн улс төрийн дүгнэлтийн шинжтэй баримт бичиг байсан юм.

Анхдугаар хурлаас баталсан оршил бичгийг бүрэн эхээр нь сийрүүлбэл:

“Эдүгээ газрын бөмбөрцөг дээрх олон улсын байдал төлөвийг үзэхүл боловсон хүчирхэг ба бүдүүлэг буурай аль ч улс дотроо их л түгшүүртэй байхын учир шалтгааныг асууваас капиталын ажил туйлдаа хүртэл боловсорч, эд таваар үйлдэх ба мөнгө зоосыг ямагт эрхлэх банкны капитал хоёр зохицон хуралдаж улс тус бүр цөөвтөр тооны бөгөөд хөрөнгө маш ихтэй хоршоо нэрлэн гадагш олон улсын хооронд харилцан нэвтэрч дам дам хоршсоор хүчин чадал аугаа ихийг олжээ.

Бүх дэлхийн бөмбөрцгийн газар усыг чухамхүү капиталын тороор ороон бүрхээд олон улсын гадаад, дотоод засгийн бодлогыг мөн хэдхэн капитал бүхий хүмүүс дур мэдэн магад хөдөлгөж буй учир засгийн эрх баригчид ба капиталтан эрхбиш хомголзох шунахай сэтгэлээр гадагш өнгийн харж, улс өөр өөрийн эрх мэдэл, ашиг тусыг хамгаалмуй, бадруулмуй хэмээн цэргийн хүчийг эрхлэн империализм хэмээгч сайх эзэрхэг түрэмгий засгийн бодлогыг сансрын гал мэт шатааж, олон хүчирхэг эзэрхэг улсууд дэлхийн бөмбөрцөг дэх худалдааны талбар болон газар орон ба олон колони хийгээд зам нэвтрэх чухал боомт газруудыг булаацалдан хэрэлдсээр хоёр анги болж харилцан тэмцэж мөнөөхөн саяын их байлдаан дэгдсэний үнэн учир тэр буюу.

Их байлдаанд ил далдаар эс оролцон холбогдсон их бага улс нэг ч үгүй учир зүг гэмтсэн цэргийн тоо гучин миллиард амь хэмээхээс гадна хол ойргүй хэд хэдэн зуун миллиард тооны ард амьтныг (түмэнг) үрэгдүүлж сүйтгэсэн нь асар үлэмж болжээ. Олон улсын дорд ард амьтан (түмэн) цөм энэхүү байлдааны далимд амь бие хөрөнгө хогшлоор үрэгдэн сүйрсэн бөгөөд гагцхүү дээр өгүүлсэн хоршоонууд ба банкууд, жич тэдний бодлогыг бүрэн бүтэн болгож өгөгч засгийн эрх баригчид дэлбэртэл баяжсан ажээ.

Цэргийн зэр зэвсэг, хүнс хоол, хувцас хунар зэрэг хэрэглэгдэхүүнийг улсын санд өндөр үнээр бэлтгэж нийлүүлэх мэтийн баяжих арга түмэн буй болой. Эдгээр баялгууд улам улам эрх чадлыг олсон бололтой. Гэтэл бас нэгэнтээгүүр хянаваас угаас Европт капитализмын ажил дэлгэрэн машины үйлдвэр улам боловсрохын хамт мөнхүү капиталын бялтад, цохилгод мөлжигдөж бүхий биеийн хүчин үнэлж амьдрагч пролетари ард эв санал нийлж шударга цагаан ажил үйлдвэрээр амьдрагч ардын Бошгыг халах суртлын бүгд нийтлэгч хэмээх нам байгуулан капиталтны дарлалаас ангижран гарч, улсын засгийн эрх мэдлийг авч, дэлхий дээрх түмэн улсын дотор капиталын хийж бүхий ажил үйлдвэрийг шударга ажлаар суугч ард иргэний эрх мэдэлд бүрмөсөн шилжүүлэн оруулж түмэн ардын тусыг нийтэд хэм тэгш бүтээсүгэй.

Капитал хөрөнгөөр үлэмж баялаг өдий төдий хүмүүс нь олон ард амьтныг (түмэнг) элдвээр дарлан мөлжиж чадахгүй болоод гадаад дотоодын эзэрхэг түрэмгий засгийн бодлогыг нэгмөсөн устгаж, бүх дэлхийн бөмбөрцөг дээр аливаа хүчирхэг нэгэн улс нь буурай нэгэн улсаа залгих түрэмгийлэхгүй, үндэс бүрийн түмэн улс бүгдээр хэм тэгш, энх төвшин, гэгээн боловсролыг эрхлэн жаргацгаахын мөрийг эрсүгэй хэмээн капиталтны эсрэг хандах хөдөлгөөнөөр он жил нэлээд уджээ.

Эдүгээ цагийн байдал урьдынхад адилгүй болоод бас ч капиталын эрхэнд автсан улс бүхий засаг нь маш шударгагүй ба хэдхэн их хоршоо ба банкнуудын ашиг олз дээрээс хүй олон ард амьтан (түмэн) талаар үрэгдсэн зэрэг учраас газар орон бүрийн ард иргэн ихэд хилэгнэж, дэлхий дээрх улс бүрийн Бошгыг халах намууд зориг бодлого нь шулуусан нэгэн чигийг олж, олон намууд харилцан нэвтрэлцэж нэгэн хэлхээ батлаад олон улсын хоорондох эв хамтын намууд хэмээгчийг оросын Москва хотноо шинэчлэн байгуулж Гуравдугаар интернационал хэмээхээр нэрийдэв. Энэхүү Гуравдугаар интернационалаас бүх дэлхий дээрх бошгыг халах хэмээсэн революцын бодлого явдлыг удирдаж буй.

Хэдийгээр тийм боловч бас капитал ёсны ажил газар бүрд нэвтрэн дэлгэрч чадсан нь адилгүй. Монгол, Төвдийн зэрэг зарим газарт ард түмэн нь хуучин бүдүүлэг суртал, түүхий ажлыг эрхлээд шашин мөргөлийг гол болгож, шашныг

баригчдад бишрэн эзэрхэг эрхэм болгож, төрийг баригч эзэд, ноёд, хаад, ван, гүнгүүдэд сөгдөн бөхийж, орон нутгийн ба улс төрийн засгийн хэрэгт оролцох эрх мэдэл огт байхгүй, зүг албат боолын хуваариар дарангуйлан захирагдаж байгаа нь эдүгээ цагийн хувьсгалд магад үл нийлэлцмүй хэмээхээс гадна төдий бүдүүлэг бүрхэг улсууд нэгмөсөн боловсон улсын ард иргэнтэй адил хөдөлж, хуучин байдлаа мөн боловсон улсын адил болтол халж яахин болох ажээ.

Зүй нь өөрийн хэрээр хичээж ард амьтныг (түмэнг) нь хэдхэн тооны угсааны ноёд гагцхүү засгийн мэдлээс ангижирч, аливаа улс төрийн хэргийг ард олноор хуралдан чуулж хэлэлцэн зөвшөөгөөд, олонд тустайгаар шийтгэвээс зохих тул тийм бүдүүлэг газар оронд хамгийн урд засгийн эрх мэдлийг ард түмэнд шилжүүлэн авч, ардын хуралт сонгуулийг эрхэлсэн гүрэн байгуулбаас зохимуй хэмээхээс гадна Төвд, Монголын зэрэг бүдүүлэг суртлын түүхий ажилд буурай ба бага улсыг гадаадын хүчирхэг улс эзэрхэг түрэмгийгээр орж дарлан ард амьтан (түмэн), орон дэлхийн шим хөрөнгийг шувт сорон мөлжиж буй учир мөнхүү эзэрхэг түрэмгий улсын харгис мэдлээс ангижран салж, тус тус өөрийн үндсийг батлан, эр чадлаа саадгүй боловсруулан хүмүүжихийг эрхэлбээс зохино.

Энэ мэтийн явдалд Москвад нийлсэн олон улсын хоорондох Гуравдугаар интернационалаас тусалмуй. Ийнхүү туслах учир юун хэмээвээс капиталаар баялаг

улсуудын эзэрхэг түрэмгий явдал нь үйлдвэрийн түмэн пролетарид ерөөс харш хэмээхээс гадна бүх бүдүүлэг сурталт, түүхий ажилт хүчин буурай аймаг улс, газар орон бүхнийг залгих, мөлжих, колони болгох мэтээр дарлаж, улам бүр хүчин чадал олох нь магад тул дэлхий дэх олон пролетари, олон буурай улс хоёулангийн нь дайсан нэгэн мөн хэмээн таньж, аливаа эзэрхэг түрэмгийн талхинаас ангижирч, түмэнд туст шударга байдлыг зохиох үйлсэд хүч хавсран туслалцах учир нь тэр буюу. Товчилбоос эдүгээ цагийн дэлхий дахины байдал төлөв нь дарлагч дарлагдагч, мөлжигч мөлжигдөгч, эзэрхэгч эзлэгдэгч, үнэнч худалч, харгис шударга хоёр этгээд эсрэг тэсрэг байлдаж ахуй их цаг хэмээвээс зохимуй.

Дэлхий дахины харгис байдлыг хамгаар халж, шинэ шударга байдлыг зохиосугай хэмээсэн явдал мөн буюу зовлонтон бүгд санал нэгдэгтүн. Хүч хавсарч буй. Харин зовоогчид нь өөр зуураа ашиг олж булаацалдан хэрэлдмүй. Энэхүү их байдал ямар мэт үзэгдэж байгаа вэ хэмээвэл урьд хэдэн зуун оны өмнө Европт мөн Монголын адил бүдүүлэг сурталтай, түүхий ажилтай агаад шашин мөргөлийг гол болгоод олон хан, ван, гүнгүүд өөр өөрийн ард албатыг боолчлон мэдэж, бүрхэг харанхуйгаар агуулан гагцхүү эрхтэн, мэдэлтэн, ноёд, сайдууд өөр өөрийнхөө жаргал, нэр цол, зэрэг хэргэмийг эрхэмлэдэг цаг агсан ажгуу.

Бас шашин төрийг баригчид харилцан засгийн эрх мэдлийг

булаацалдан эвдрэлцдэг цаг бөлгөө. Тэр цагийг Европын сударт дундад зууны феодалын байдалт үес хэмээжээ. Феодал хэмээгч даруй ван, гүнгүүдийн нэр мөн. Манай Монголын эдүгээгийн байдал төлөв нь тэрхүү дундад зууны үес лүгээ бараг адил мэт үзэгдмүй. Учир төлөв ийм тул манай Монголыг капиталын ёс дэлгэрсэн хүчирхэг боловсон улсын адил хэлэлцэж үл болно. Эрхбиш боловсрол нь дундад зууны үесээс дэмий хол өнгөрөөгүй бүхийг харгалзуулж эдүгээгийн байдлыг зүйгээр шинжлэн халах явдлыг үйлдвээс зохино.

Гэвч капиталын хүчин чадал нь дэлхий дээр зэргээр үл хүрэлцээд газар орон огт үгүй, бас шинэ шударга байдлыг эрмэлзэн бүхий олон улсын ард иргэний Бошгыг халах намуудын суртал дэлгэрч чадаагүй газар оронгүй болжээ. Тэр тул бүх дэлхий дээр ямар ямар ихээхэн хувьсгал болж байгаа нь эрхбиш манай хязгаар монгол газарт ч үзэгдмүй.

Өөр дурдваас Европын хүчирхэг улсуудын эзэрхэг түрэмгийн хамт манай Монголын уудам сайхан нутагт тариалангийн ард иргэнийг суулгаж, дэлхийн олон уурхайн зэрэг баялгийг ашиглан Монголын элбэгхэн малын ажил эрхэлдгээс гарах түүхий эдийн зүйлийг горьдож, Монголын газар оронг эрх мэдэлдээ оруулан өөрийн захиргааны колони хэмээх газар болгосугай хэмээн урьд эзэрхэг засагт Орос улсаас өнгөлзөн түрэмгийлсэн ба бүр сүүлийн эцэст Оросын эзэрхэг түрэмгий хомхой

шунал нь дотроос халагдахын хамт Умард Хятадын авьяас их л хөдөлж, цэргийн хүчээр түрэн орж ирээд мөнхүү Монгол улсыг Хятадын колони болгож үүрд мөлжин ашигласугай хэмээн харгис ширүүнээр манай Монголын үндсийг балруулан, Монголын буй бүхий ашиг орлогын зүйлүүдийг хаман авч, эзэрхэн түрэмгийлсэн нь нүдний өмнө үзэгдсээр тул юун өгүүлмүй. Энэ болбоос цөм капиталын ёсны эрх бүхий улсууд бүгд ашигт ханахгүйн бэлээхэн гэрч буюу” гэж бичсэн байна.

Их хурал, Зөвлөгөөний протокол орос хэлээр бичигдсэн бөгөөд тэрхүү гар бичмэл эхийг бичгийн хэв сайтай орос, эсвэл буриад хүн бичсэн бололтой байна. Учир нь Ж.Цэвээний нэрийг “Цывен-Бурят, Цывен Жамсарано (Бегзеев)” (Бегзеев гэдэг нь түүний нийтлэлдээ хэрэглэдэг нэр юм), Шавийн отог Манзушир гэхийг “Шаби отока Манзашири”, Дэндэвдож гэхийг “Дындыбдоржи” Лувсан гэхийг Лобсан, Дашзэгвэ гэхийг Дашзыгбэ, Сүжигт гүн гэхийг “Сүзүктү гуна” гэх мэтээр бичсэн нь яав ч монгол хүн бичээгүйг харуулж байна. Хурлын тэмдэглэлд, өнөөгийнхөөр бол нарийн бичгийн дарга нар буюу тухайн үеийнхээр «“бичээч” нарт Одсэр, Дамбадорж, Балмасоо нарыг сонгов» гэж байгаа бөгөөд тэд тэмдэглэлийг оросоор бичсэн баймааргүй санагдана.

Хурлаар хэлэлцсэн үндсэн асуудал болох Оршил бичиг, Эрмэлзэх зүйлүүд монгол хэл бичгээр байхад тэмдэглэл (протокол)-

ийг орос хэлээр бичсэн нь анхаарал татаж байгаа юм. Хуралд Зөвлөлт засгийн Гадаад яамны төлөөлөгч Макстенек оролцож хэлсэн үгэндээ “Гадаад Монголын ард түмний гадна дотнын харгис гашуун зовлонгоос ангижран өөртөө эзэрхэх төр байгуулж, эрх мэдэл ба ард түмэнд тустай их үйлсээ ариун сайхнаар бүтээхийн тул Монгол Ардын Нам байгуулсанд манай Оросын Зөвлөлт засгийн нэрээс маш их баяр хүргээд, бас ард түмний гадна дотнын харгис дайсны зовлонгоос гэтлэх үйлсэд манай Зөвлөлт засгийн газраас үргэлж тусламжийг үзүүлэх болно” хэмээн мэдэгдсэн байна. Тэр хүний бичсэн тэмдэглэл үлдэж хоцорсон юм биш биз гэх бодол ч төрөхөөр байгаа юм. Хурлаас гаргасан нэг шийдвэр бол Монгол Ардын Намын дэргэд Олон улсын хоорондох Эв хамтын олон намуудын Алс Дорнодын хэлтсээс томилон гаргасан төлөөний түшмэл нэгийг суулгах болсон явдал байв. Үүнээс үзвэл Коминтерны төлөөлөгч нам байгуулагдсан анхны өдрөөс эхлэн Монгол Ардын Намын үйл ажиллагаанд заавар зөвлөгөө өгч байнга ажиллах болсон байна.

Хурлын тэмдэглэлийн эхэнд “Монгол Ардын Намын 26 хүмүүс ба гишүүн” 1921 оны 3 дугаар сарын 1-ний хуралд оролцсон гэсэн боловч протоколын эцэст Данзан, Сүхбаатар, Билигсайхан, Лосол, Пунцаг, Содномдаш, Дамбадорж, Бадарчин, Дашзэгвэ, Равжаа, Осор, Дамдинсүрэн, гэхийг Нэрваан, Лувсан, Цэвээн, Цэдэн-Иш, Балмасоо нарын 17 хүний нэрийг жагсаажээ.

Мөн 3 дугаар сарын 2-ны өдрийн зөвлөгөөнд Данзан, Сүхбаатар, Билигсайхан, Пунцаг, Содномдаш, Дашзэгвэ, Дамдинсүрэн, Далай, Дамдинсүрэн, Цэвээн, Лосол, Бадарчин, Дамбадорж, Дамбаравжаа, Должин-Осор, Сандаг, Цэдэн-Иш, Наваан, Балмасоо нарын 19 хүн оролцож өдрийн 15 цагаас эхэлж шөнийн 11 цагт тарсан гэсэн бол, 3 дугаар сарын 3-



Дээр дурдсан баримтууд нь нэгдүгээрт, Ж.Цэвээн Монгол Ардын Намын анхны гишүүдийн нэг байсан, хоёрдугаарт, Монгол Ардын Намыг үүсгэн байгуулах анхдугаар Их хурлын дэд даргаар сонгогдож байсан, гуравдугаарт, Намын үндсэн баримт бичиг болох Тунхаглан зарлах бичгийн оршил, Эрмэлзэх зүйлүүд гэсэн хоёр бичгийг боловсруулж хэлэлцүүлсэн зүтгэлтэн болохыг харуулж байна.



ны өдрийн зөвлөгөөнд саналын эрхтэй оролцсон хүмүүс гэдэгт Сүхбаатар, Пунцаг, Данзан, Далай, Осор, Билигсайхан, Дамдинсүрэн, Дашзэгвэ, Сэнгээ, Амар, Юриндамба, Дамдинсүрэн, Содномдаш, Равжаа, Дэндэвдорж, Баярт, Наваан, Дамбадорж, Бадарчин, Лувсан, Лосол, Цэвээн нарын 22 хүний нэрийг жагсаасан байна. Эдгээр

нэрс Монгол Ардын Намын ууган зүтгэлтнүүд хийгээд намыг байгуулахад тэдний гүйцэтгэсэн үүр-гийг тодруулахад хэрэг болох болов уу гэсэн санаагаар зориуд дурдсан болно. Жишээ нь хожим нэрт эрдэмтэн, академич болсон Бямбын Ринченгийн багш Билэгсайхан, Эрхүүд Д.Сүхбаатар нарын хамт ажиллаж байсан Бадарчин нарын зэрэг урьд өмнө Монгол Ардын Намын түүхэнд нэр гардаггүй байсан хүмүүс Намын анхдугаар их хурлын төлөөлөгчөөр сонгогдон оролцсон байх юм.

Дээр дурдсан баримтууд нь *нэгдүгээрт*, Ж.Цэвээн Монгол Ардын Намын анхны гишүүдийн нэг байсан, *хоёрдугаарт*, Монгол Ардын Намыг үүсгэн байгуулах анхдугаар Их хурлын дэд даргаар сонгогдож байсан, *гуравдугаарт*, Намын үндсэн баримт бичиг болох Тунхаглан зарлах бичгийн оршил, Эрмэлзэх зүйлүүд гэсэн хоёр бичгийг боловсруулж хэлэлцүүлсэн зүтгэлтэн болохыг харуулж байна.

Эшлэл

1. 1921. Монгол Ардын Намын хурлын бичиг. Гар бичмэл. (Орос хэлээр).
2. 1921. Монгол Ардын Намын хурлын бичиг. Гар бичмэл. (Орос хэлээр).
3. 1921. Монгол Ардын Намын хурлын бичиг. Гар бичмэл. (Орос хэлээр).
4. 1921. Монгол Ардын Намын хурлын бичиг. Гар бичмэл. (Орос хэлээр).

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 1921. Монгол Ардын Намын хурлын бичиг. Гар бичмэл. (Орос хэлээр)
2. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. УБ.,
3. Батсүрэн Д. 2020. (Эмхт) Түүхч, архивч Чойдогийн Мижээхүү. УБ.,

Summary

J.Tseveen, the founder of Mongolia's first periodical, was persecuted as a Westerner in the second half of the 1920s and forced to leave Mongolia and sent to Russia, where he was imprisoned on false charges and killed. From that time on, J.Tseveen was painted as an oppositionist and a propagandist of Western ideology, and his merits were suppressed. He was acquitted in the late 1950s, but he has not done enough to restore his dignity and put in place the merits of Mongolia's intellectual sector.

To this day, little has been said or written about his role in founding the Mongolian People's Party. However, a document written in black on a white sheet of paper testifying that he was the first leader and main ideologue of the Mongolian People's Party was found in the personal archives of Ch.Mijeekhuu. The document contains the minutes of the Congress of the Mongolian People's Party held on March 1, 1921 (then called the "People's Party Meeting" and renamed the Parliament in 1924), the meetings held on March 2 and 3. It is a complex source consisting of the introduction to the proclamation of the People's Party, the ten aspirations of the Party, and the names of those who participated in the Congress and the conference.